

**НЭГДСЭН ТӨСЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗАР ОНӨТҮГ
ХУУЛЬ, ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2026 ОНЫ 1 ДҮГЭЭР
УЛИРЛЫН БИЕЛЭЛТИЙН ҮНЭЛГЭЭ**

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн 2026 оны 1 дүгээр улирлын хэрэгжилтийн дүн:

Шийдвэрийн төрөл	Шийдвэрийн тоо	Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэхээр тусгасан заалтын тоо
Засгийн газрын тогтоол	4	6
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	6
Засгийн газрын албан даалгавар	3	4
Нийт	11	16

Нийт 11 шийдвэрийн 16 заалтын биелэлтийг нэгтгэн Монгол улсын Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 183 дугаар тогтоолын батласан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ын 6.2-д заасан аргачлалаар дүгнэлээ. Гурван заалтад хамаарч буй зарим ажлуудыг нэгтгэн, гүйцэтгэлийн хувь тооцоход бэрхшээлтэй байгаа тул “хэрэгжих шатанд” удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай/ 50% хүртэл үнэлгээнд хамруулж үнэллээ.

Үнэлгээ	Заалтын тоо
Засгийн газрын тогтоолын хэрэгжилт (4 тогтоол)	
Хэрэгжсэн	100%
Хэрэгжих шатанд	50%
Хэрэгжээгүй	0%
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
Хэрэгжих болоогүй	
Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилт (4 гүйцэтгэл 5 заалт)	
Хэрэгжсэн	100%
Хэрэгжих шатанд	50%
Хэрэгжээгүй	0%
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
Хэрэгжих болоогүй	
Засгийн газрын албан даалгавар (3 гүйцэтгэл 4 заалт)	
Хэрэгжсэн	100%
Хэрэгжих шатанд	50%
Хэрэгжээгүй	0%
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	
Хэрэгжих болоогүй	
Хэрэгжилтийн дундаж үнэлгээ	90.6% буюу “Хэрэгжсэн”

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Ө.ТҮВШИНЖАРГАЛ

К.ЛХАГВАСҮРЭН

Ц.ТУЯА

“Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ
Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт
2026 оны I улирал

2026 оны 04 дүгээр сарын 14

Улаанбаатар хот

Шийдвэр Д/д	Засгийн газрын Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ
65	155	Төлөвлөгөө батлах тухай 2023-06-14 Дугаар 2023_231	Холбогдох заалтын агуулга 2..2.Төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг байгууллагын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийг хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулан зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, байгууллагын дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний комисс, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим, Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, бизнесийн мэргэжлийн холбоод, Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбоо, иргэний	Хэрэгжилтийн явц Засгийн газрын тогтоол Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 231 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Бизнес үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах, хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.5-ийн хүрээнд: Зорилт 2 дүрмээр хүлээсэн чиг үүргийн 2.1.1. Төсөл хөтөлбөрүүдийн техник эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтын гэрээ, тендерийн баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн санал, зөвлөмж өгөх, 2.1.4. Төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт татах зорилгоор дотоодын болон олон улсын хөгжлийн банк, санхүүгийн байгууллагуудтай уулзалт хийх, хөрөнгө оруулалтын форум, вебинарт төслүүдийг танилцуулах, хамтран зохион байгуулах, 2.2.1. Байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоог зохион байгуулах, 2.6.7 Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, зохион байгууллан, нийтэд мэдээлэх. Бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.8, 2.13, хүрээнд: Зорилт 2 дүрмээр хүлээсэн чиг үүргийн 2.5.2. Олон улсын болон ижил төстэй амжилттай хэрэгжиж буй төслийн туршлага солилцох уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг дотооддоо зохион байгуулах, 2.5.3. Төслийн удирдлагын олон улсын стандарт, арга аргачлал, журамд суурилсан сургалт, туршлага мэдлэг солилцох уулзалт зохион байгуулах, мэргэжлийн зөвлөмж зөвлөгөө үзүүлэх 2.6.15 Хүний нөөцийг	100

65	155		<p>нийгмийн байгууллагуудад тус тус зөвлөсүгэй.</p>	<p>бүрдүүлэх, сонгон шалгаруулах, мэргэшүүлэх ажлыг гүйцэтгэж, сургалт хөгжлийг төлөвлөн хэрэгжүүлэх 2.6.16. Байгууллагын үйл ажиллагааны үр дүнд бий болдог захиргааны болон албан ёсны статистикийн тоон мэдээллийг цуглуулах, нэгтгэх, мэдээлэх тогтолцоог бий болгох.</p> <p>Бизнес үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.14-ийн хүрээнд: Зорилт 3: Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 3.6. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах , гэж тус тус тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p>
68	162	<p>Нийслэлийн авто замын сүлжээг өргөтгөх талаар авах арга хэмжээний тухай 2025-01-29 Дугаар 2025_40</p>	<p>1. 1.2025 оныг “Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлийн авто замын түгжрэлийг бууруулах төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд “Туул хурдны зам”, “Сэлбэ хурдны зам”, “Улаанбаатар хотын тойрог хурдны зам”-ын зурвас газрын эргэлтийн цэг, солбицлыг тогтоож, Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Учрал, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай.</p>	<p>Монгол Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 173 дугаар тогтоолоор “Авто замын эхлэл төгсгөлийн болон эргэлтийн цэг, солбилцол” батлах тухай Нэгдүгээр тойрог зам, Хоёрдугаар тойрог зам, Туулын хурдны замын эргэлтийн цэг солбилцол батлах тухай тогтоол батлагдсан болно.</p> <p>Мөн 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Зам, тээврийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталсан. 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Хот байгуулалт, Хотын стандартын газрын мэргэжлийн зөвлөлийн хуралд, 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр барилга Хот байгуулалт, Барилга, Орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хуралд тус тус танилцуулагдсан.</p> <p>100</p>

		<p>2. 2. “Нэгдүгээр тойрог зам” төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үлдэгдэл 2,817.2 (хоёр их наяд найман зуун арван долоон тэрбум хоёр зуун сая) тэрбум төгрөгийн зардалд Засгийн газрын өрийн баталгаа гаргах болон “Хоёрдугаар тойрог зам” төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх асуудлаар санал боловсруулан 2025 оны 2 дугаар улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар нарт тус тус даалгасгай.</p>	<p>Нэгдүгээр тойрог зам 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн Засгийн газрын 173 дугаар “Авто замын эхлэл төгсгөлийн болон эргэлтийн цэг, солбилцол” батлагдсан. Нэгдүгээр тойрог замын ТЭЗҮ-ээр зам барилгын бүтээн байгуулалтын ажилд нийтдээ 918 сая ам.долларын төсөвт өртөг шаардлагатай тооцоо судалгаа гарсан. 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Улсын Их хурлаар хэлэлцүүлж, 2025 онд ашиглах 260.3 сая ам.долларын үндсэн болон хүүгийн төлбөрийн 85 хувь хүртэлх хэмжээнд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2025 оны төсвийн жилд багтаан Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг авч хэрэгжүүлэхийг Улсын Их хурлын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 86 дугаар тогтоолоор зөвшөөрсөн.</p> <p>НХОГ/20250101007 дугаартай “Нэгдүгээр тойрог зам”-ын зураг төсөл, худалдан авалт, зам, замын байгууламжийн барилга угсралтын ажил, санхүүжилт (ЕРС+F)-ийн тендерийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-аас 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр зарласан бөгөөд 2026 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр тендерийг нээсэн, тендэрт материал ирүүлсэн аж, ахуйн нэгжүүд шаардлага хангаагүй боловч хуулийн хүрээнд тендер үнэлэх ажил хийгдэж байна.</p>	100
80	<p>Нийслэл Улаанбаат ар хотод барих тойрог хурдны замын талаар авах</p>		<p>Хоёрдугаар тойрог авто замын төслийн ТЭЗҮ-г Зам, тээврийн яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дэргэдэх Авто замын салбарын дэд зөвлөлийн хурлаар 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдөр хэлэлцүүлсэн бөгөөд дахин хэлэлцүүлэхээр Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлын бүрэлдэхүүн тов гаргаж мэдэгдэхийг хүлээж байна. Гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон бөгөөд гэрээний хугацааг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна. Төр хувийн хэвшлийн түншлэлээр төслийн барилга угсралтын ажлын тендерийг зарлахад бэлтгэх, мөн Улсын Их хурлын өрийн баталгаа гаргуулах ажил болон бусад бэлтгэл ханган ажиллаж байна.</p>	50

	182	<p>“Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2025-05-28 Дугаар 2025_272</p>	<p>3. “Үндэсний хүрээлэн-Үндэсний амралтын хүрээлэн” шугамын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон загвар зургийг боловсруулах ажлыг төслийн үндсэн эх үүсвэрээс санхүүжүүлж, бүтээн байгуулалтын ажлыг 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хэрэгжүүлэхийг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус даалгасгай</p>	<p>“Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ-ын захирлын 2026 оны А/33 дугаар тушаалын дагуу Үндэсний цэцэрлэгт хүрээлэн – Үндэсний соёл, амралтын хүрээлэн чиглэлийн техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын даалгаврыг боловсруулж батлуулах, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нэгдсэн төслийн удирдлагын газрын холбогдох хэлтсүүдээс санал авч ажиллаж байна.</p>	100
81	230	<p>5.24.1.3. Туулын хурдны зам болон босоо тэнхлэгийн I тойрог замыг Чингис хаан нисэх буудалтай холбох ажлын төлөвлөлт, авто зам, гүүр, гүүрэн байгууламжийн бусад төслүүдийн харилцан уялдааг хангах арга хэмжээний саналаа бэлтгэн танилцуулахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;</p>	<p>Нэгдүгээр тойрог авто зам нь баруун талаараа Яармагын шинэ гүүр, Зүүн талаараа Жанжин клуб орчимд Туулын хурдны замтай холбогдоно. Хоёрдугаар тойрог зам нь баруун талдаа 22 товчооны тойрог орчимд Туулын хурдны замтай холбогдож, Баянхошуу орчимд Нэгдүгээр тойрог замтай холбогдоно. Зүүн талаараа Да хүрээ орчимд нэгдүгээр тойрогтой холбогдож Улиастай орчимд үргэлжлэж, Туулын хурдны замтай Баянзүрхийн товчооны орчимд холбогдоно. Энэхүү саналыг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Зам, тээврийн яамны дэргэдэх Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталсан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр Хот байгуулалт, Хотын стандартын газрийн мэргэжлийн зөвлөлийн хуралд, 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр барилга Хот байгуулалт, Барилга, Орон сууцжуулалтын яамны дэргэдэх Шинжлэх ухаан, техник, технологийн зөвлөлийн хуралд тус тус танилцуулагдсан.</p>	100	

116		<p>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-01-29 Дугаар 2025_06</p>	<p>6.6.1. “Өөдөө тэмүүлэх Монгол” ган татлагат гүүр, “Хөнгөн галт тэрэгний шугам” төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт;(Нийслэлийн авто замын сүлжээг өргөтгөх талаар авах арга хэмжээний тухай)</p>	<p>Нэгдүгээр шугам нь Зуслангийн бүс “Зунжин худалдааны төв”-өөс Сүхбаатарын талбай хүртэлх чиглэл: “Нийтийн тээврийн Улаанбаатар трам (Хөнгөн галт тэрэг-LRT) төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлийг “Шугам 1”-ийн “Зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх” (DBFOM) төрлийн сонгон шалгаруулалтад оролцох урьдчилсан шалгаруулалтыг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 16:00 цаг хүртэл зарласан боловч хувийн хэвшлээс санал ирүүлээгүй тул 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цаг хүртэл дахин зарласан.</p> <p>Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах, үнэлгээгээр тогтоогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч, төслийн нөлөөлөлд өртөх 4 дүүргийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, санал хүсэлтийг авч ажилласан.</p> <p>Мөн БОННУ боловсруулах ажлын хүрээнд туслан гүйцэтгэгч “Сайхан Ариун Дэлхий” ХХК эхлэлийн тайланг хүргүүлж, холбогдох төрийн захиргааны байгууллагуудаас хамааралтай ажлуудыг хэрэгжүүлэх шаардлага үүссэнтэй холбогдуулан БОННУ гүйцэтгэх хугацааг сунгах асуудлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн. Үүний зэрэгцээ БОННУ-г Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2026 оны 03 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн.</p> <p>Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сонирхогч талуудтай хамтран ажиллаж, Улаанбаатар түншлэл төвтэй уялдаа холбоог ханган, хотын төвийн буудал, авто замын төлөвлөлтийг нэгдсэн байдлаар боловсруулах чиглэлээр хамтран ажилласан.</p> <p>Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулагдаж дууссан 2026 оны 04 дүгээр сарын 20-ний дотор БОУАӨЯ-наас QR код авахаар ажиллаж байна.</p>
233			<p>50</p>	

			<p>Хоёрдугаар шугам нь Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбай хүртэлх чиглэл:</p> <p>“Нийтийн тээврийн Улаанбаатар трам (Хөнгөн галт тэрэг-LRT) төслийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлийг “Шугам 1”-ийн “Зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах, шилжүүлэх” (DBFOM) төрлийн урьдчилсан шалгаруулалтад оролцох хүсэлтийг 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 16:00 цаг хүртэл хүлээн авсан боловч хувийн хэвшлээс санал ирүүлээгүй тул 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 16:00 цаг хүртэл дахин зарласан.</p> <p>Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ)-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг хангах, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд анхаарч, төслийн нөлөөлөлд өртөх 4 дүүргийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, санал хүсэлтийг авч ажилласан. БОННУ-г Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны мэргэжлийн зөвлөлийн хурлаар 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцүүлж, дэмжигдсэн.</p> <p>Нийслэлийн Засаг даргын А/146 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд техникийн тодорхойлолтод санал, зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажилласан.</p> <p>Улаанбаатар трам төслийн Шугам 2-ын бүтээн байгуулалтын ажлын ЕРС нээлттэй тендерийг 2026 оны 03 дугаар сарын 13-ны өдөр албан ёсоор зарласан бөгөөд тендерийн нээлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулна.</p>	100
118	239	<p>13.19.2 Шаардлагатай тохиолдолд хэлцэл хийх хүрээнд мэргэжил, арга зүйн зөвлөх үйлчилгээ авах асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлж ажиллахыг</p>	<p>Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 55 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийг хуралдуулах саналыг Нэгдсэн төслийн удирдлагын газар ОНӨТҮГ-аас 2025 оны 05 дугаар сарын 30-нд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Сангийн сайдад хүргүүлсэн боловч тухайн үеийн засаг захиргааны бүтцийн өөрчлөлтийн улмаас хуралдаан хойшлогдсон.</p>	100

		<p>сарын 19-ний өдрийн 13 дугаар хуралдааны тэмдэглэл 2025-03-19 Дугаар 2025_13</p>	<p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатарт даалгав.” (1.Монгол Улсын Засгийн газраас 2025 оныг “Нийслэлийн дэд бүтцийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийслэл Улаанбаатар хотын Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл, арга хэмжээний санхүүжилтийн талаар Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Засгийн газрын Экспорт, зээлийн агентлагтай яриа хэлэлцээ хийх Ажлын хэсэг байгуулах тухай)</p>	<p>Мөн төслийн бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг UKЕF-ийн баталгаатайгаар зохицуулах хувилбар нь Сангийн яамнаас дэмжигдээгүй тул Олон талт хөгжлийн банкууд болон олон улсын санхүүгийн байгууллагуудтай уулзаж өөр боломжит хувилбарыг судалж эхэлсэн. Үүний дагуу төслийн менежментийн зөвлөх компанийн зөвлөсний дагуу тендерийг хоёр багцад хуваасан бөгөөд Багц-1-ийг ЕРС+F (Зураг төсөл, барилга угсралт + Санхүүжилт) нөхцөлтэйгөөр 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдөр нээлттэй зарласан. Багц-2-ын санхүүжилтийг Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕВRD)-ны дэмжлэгтэйгээр шийдвэрлэх чиглэлээр хамтын ажиллагааг үргэлжлүүлж байна</p> <p>Их багтаамжийн нийтийн тээвэр буюу "Метро"-г барьж байгуулах төслийн нээлттэй тендер шалгаруулалттай холбоотойгоор оролцогч талуудаас ирүүлсэн хүсэлтийг Үнэлгээний хороо хэлэлцэн шийдвэрлэсний дагуу тендер хүлээн авах хугацааг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдөр хүртэл сунгагдсан. Мөн төслийн барилга угсралтын хугацааг 60 сар, зүгшүүлэлт болон туршилтын хугацааг 6 сар байхаар тус тус тодорхойлж, холбогдох тодруулгыг tender.gov.mn цахим системд байршуулсан болно</p>	50
	120	246	<p>15.13.8.3.. Нийслэл Улаанбаатар хотод бохирдол үүсгэж байгаа үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагыг 2025 оны 08 дугаар сараас өмнө урьдчилан цэвэрлэх байгууламжтай болгох, хуулийн дагуу хяналт тавьж ажиллах, гэр хорооллын лагийг хүлээн авч цэвэрлэх дэд төвүүдийг байгуулах ажлыг зохион байгуулахыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Ж.Батсуурь, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарт нарт.”</p>	<p>Лаг шатаах үйлдвэр төслийн хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн талаар зах зээлийн судалгаа хийх, хувийн хэвшлийн түншлэгчийн хөрөнгө оруулалтыг татах, тандан судлах, хувийн хэвшлийн түншлэгчийг тодорхойлох зорилгоор Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам”-ын 2.2-т заасан мэдээлэл, тооцоо, шинжилгээ, судалгаа бүхий төслийн саналыг хүлээн авч дууссан. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, журмын дагуу “Лаг шатаах үйлдвэр” төслийн саналд “Улаанбаатар түншлэл төв” ХХК урьдчилсан үнэлгээг хийж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар баталгаажуулсан.</p> <p>Мөн Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/05 дугаар захирамжаар Бүрэн шинжилгээний ажлын хэсэг байгуулагдаж, зах зээлийн</p>	50

				<p>судалгаа хийх, хөрөнгө оруулалтын боломжийг тодорхойлох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа холбогдох хууль, журмын дагуу үе шаттай хэрэгжиж байгаа бөгөөд техник, санхүүгийн болон хууль эрх зүйн нарийвчилсан судалгааг эхлүүлсэн байна.</p>
140	308	<p>Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 04 дугаар хуралдааны тэмдэглэл 2026-01-28 Дугаар 2026_04</p>	<p>19.1.1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;</p>	<p>Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9.3.12-т "Олон төрөлт, ухаалаг нийтийн тээврийг хэрэглээнд нэвтрүүлнэ" Улаанбаатар Метро төсөл, Улаанбаатар Трам төсөл, 9.3.15-д "Агаарын дүүжин замын тээвэр"-ийг нэвтрүүлж, зориулалтын зогсоол, дэд бүтцийг барьж байгуулна" Дүүжин замын тээвэр (cable car) төсөл, 9.3.16-д "Тусгай замын автобусны сүлжээг байгуулна" Тусгай замын автобус (BRT) төсөл, Улаанбаатар хотын авто замын сүлжээг нэмэгдүүлэх, түгжрэлийг бууруулах, хөдөлгөөний зохион байгуулалтыг сайжруулах зорилгын хүрээнд 9.3.13-т "Хотын хэвтээ, босоо, тойрог чиглэлийн авто замын сүлжээ, дагуул, хаяа хотын авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ" "Шинэ тойрог зам" Нэгдүгээр тойрог зам төсөл, Хоёрдугаар тойрог зам төсөл, 9.2.15-д "Усны нөөц, ундны усны баталгаат эх үүсвэрээр хангаж хамгаалан, усны үнэ цэнийг нэмэгдүүлж зохистой хэрэглээг эдийн засгийн аргаар хэвшүүлнэ", 9.2.17-д "Ундны усны нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр "Туул усан цогцолбор" төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төслийг боловсруулан ашиглалтад оруулна" Туул усан цогцолбор, 9.3.39-д "Хаягдал лаг, тундасыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгох, эргүүлэн ашиглах гол шугам сүлжээг барих төслийг хэрэгжүүлнэ" гэж тус тус тусгасны дагуу Хөрсний ус, үерийн хамгаалалтын төсөл, Туул усан сан цогцолбор төсөл болон Лаг шатаах үйлдвэр нийт 9 төслийг "Нэгдсэн төслийн удирдлагын газар" ОНӨТҮГ эрчимжүүлэн ажиллаж байна. Уг 9 төслөөс барилга угсралтын шатанд "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэрт нэвтрүүлэх төсөл"-ийн барилга</p>

			<p>угсралтын ажил 60 хувь, Гүйцэтгэгч сонгон шалгаруулах, тендер зарлагдсан 3 төсөл, үүнд: "Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро байгуулах төсөл", "Нэгдүгээр шинэ тойрог зам барих төсөл" "Улаанбаатар Трам" хөнгөн галт тэрэг барих төслийн хүрээнд Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбайн чиглэлд 15 км, 23 зогсоол, 1 депо бүхий хоёрдугаар шугам, Техник, эдийн засгийн үндэслэлийн дууссан Лаг шатаах үйлдвэр төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн дуусах шатанд байгаа 4 төсөл, үүнд, "Хоёрдугаар шинэ тойрог зам барих төсөл", "Тусгай замын автобус BRT төсөл", "Туул усан цогцолбор төсөл" "Хөрсний ус, үерийн хамгаалалтын төсөл" байна.</p>		<p>309</p> <p>19.2.4. "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов;</p>	<p>100</p> <p>"Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 1.1.5.3.Толгойтоос Амгалан хүртэл Энхтайваны өргөн чөлөө дагуу 17.7 км "Их багтаамжийн нийтийн тээвэр Метро шугам-1", Ард Аюушийн өргөн чөлөө-Их тойруу-Намъянжүгийн гудамж-Нийслэл хүрээ өргөн чөлөө дагуу 11.9 км урт тусгай замын автобус "BRT Шугам-1", Яармагаас Хархорин хүртэл Туул гол дээгүүр 4.2 км урт "Дүүжин тээвэр шугам-1" бүхий олон төрөлт их багтаамжийн нийтийн тээврийн системүүдийн уялдаа холбоог хангаж, зорчигч тээврийн логистик төвийн хамт үе шаттайгаар барьж байгуулна "Улаанбаатар Метро төсөл, Улаанбаатар Трам төсөл, Тусгай замын автобус (BRT) төсөл, Дүүжин замын тээвэр (cable car) төсөл". 1.1.5.4. Олон улсын чанартай 88 км "Шинэ тойрог зам", Туулын хурдны авто замыг барьж, ачаа тээврийн хөдөлгөөнийг хотын гадуур тойруулна "Нэгдүгээр тойрог зам, Хоёрдугаар тойрог зам" 1.1.2.4.Хог шатаах аргаар эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийн төслийг дэмжинэ "Лаг шатаах үйлдвэр төсөл" 3.4.3.4.Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөж, шинээр барьж, стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлнэ "Хөрсний ус, үерийн хамгаалалтын төсөл" 1.1.4.7. "Туул усан цогцолбор төсөл"-ийг хэрэгжүүлж, үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, ундны ус,</p>
--	--	--	--	--	--	---

			<p>ахуйн усан хангамжийг нэмэгдүүлнэ “Туул усан сан цогцолбор төсөл” нийт 9 төслийг “Нэгдсэн төслийн удирдлагын газар” ОНӨТҮГ эрчимжүүлэн ажиллаж байна. Уг 9 төслөөс барилга угсралтын шатанд “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэрт нэвтрүүлэх төсөл”-ийн барилга угсралтын ажил 60 хувь, Гүйцэтгэгч сонгон шалгаруулах, тендер зарлагдсан 3 төсөл, үүнд: “Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл Метро байгуулах төсөл”, “Нэгдүгээр шинэ тойрог зам барих төсөл” “Улаанбаатар Трам” хөнгөн галт тэрэг барих төслийн хүрээнд Архивын ерөнхий газраас Сүхбаатарын талбайн чиглэлд 15 км, 23 зогсоол, 1 депо бүхий хоёрдугаар шугам, Техник, эдийн засгийн үндэслэлийн дууссан Лаг шатаах үйлдвэр төсөл, техник, эдийн засгийн үндэслэлийн дуусах шатанд байгаа 4 төсөл, үүнд, “Хоёрдугаар шинэ тойрог зам барих төсөл”, “Тусгай замын автобус BRT төсөл”, “Туул усан цогцолбор төсөл” “Хөрсний ус, үерийн хамгаалалтын төсөл” байна.</p>	
Засгийн газрын албан даалгавар				
144	<p>Сар шинийн баярын өдрүүдэд онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах, иргэдийн амь нас, эрүүл</p>	<p>3..3.Эрхэлсэн салбар, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хариуцлагатай шуурхай алба”-ыг байгуулж, нэгдсэн удирдлага, мэдээллийн урсгалыг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай</p>	<p>Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит 2026 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн шуурхай зөвлөгөөн дээр Засаг даргын нэгдүгээр орлогч Т.Даваадалай удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг удирдан явуулж, сар шинийн баярын өдрүүдэд хэрхэн ажиллах чиглэлээр зарим үүрэг даалгаврыг өгсөн. Сар шинийн баярын өдрүүд буюу 2026 оны 02 дугаар сарын 17-23-ныг дуустал инженер хангамжийн болон нутгийн захиргааны 12 байгууллагын удирдах албан тушаалтан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв”-д жижүүрлэн ажиллаж Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирал хуваарийн дагуу жижүүрлэн хэрэгжилтийг хангаж ажилласан.</p>	100

	322	<p>мэнд, эд хөрөнгийг хамгаалах "Хариуцлагатай шуурхай алба" ажиллуулах тухай 2026-01</p>	<p>4..4.Албан хэрэгжилтийг 2026 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 08:00 цагаас 2026 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 09:00 цаг хүртэлх хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж, аюул, осол, онцгой нөхцөл байдлын мэдээллийг Засгийн газрын Шуурхай албанд 2 цаг тутамд хүргүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Нэгдсэн төслийн удирдлагын газрын захирлын 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн "Хариуцлагатай жижүүр батлах тухай" А/13 дугаар тушаалаар Монгол үндэсний уламжлалт Цагаан сарын баярын өдрүүдэд (2026.02.17 - 2026.02.22) хариуцлагатай жижүүрийг томилж, хуваарын дагуу бүх жижүүрүүд ирж өрөөний шалгалтуудыг хийж албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>100</p>
145	323	<p>Төрийн зарим үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2026-02-11 Дугаар 2026_02</p>	<p>1.1.1.. 1.1.Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. 1.1.1.иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр хүргэж байгаа үйлчилгээг оновчилж, хүсэлт шийдвэрлэлтийн явцыг тухай бүр иргэн, хуулийн этгээдэд эргэн мэдэгдэх нөхцөлийг бүрдүүлэх;</p>	<p>"Нэгдсэн төслийн удирдлагын газар" ОНӨТҮГ-ын үйл ажиллагаанд цахим шилжилтийг үе шаттайгаар нэвтрүүлж байна.</p> <p>Тухайлбал, байгууллагын албан ёсны цахим хуудас www.iri.u.mn -ээр өдөр тутмын үйл ажиллагааны мэдээ, тайлан, бодлогын баримт бичгүүдийг ил тод, шуурхай хүргэж байна. Энэ хүрээнд цахим системийн мэдээллийг тогтмол шинэчилж, хүртээмжийг нэмэгдүүлснээр иргэд, хуулийн этгээд шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй авах боломжийг хангаж байна. Мөн тендер нь зарлагдсан төслүүдийн явц, хөрөнгө оруулалт, авч буй арга хэмжээг цахим хуудсаар дамжуулан урьдчилан болон тухай бүр мэдээлж, ил тод байдлыг хангаж 2026 оны нэгдүгээр улирлын байдлаар хэрэгжүүлж буй төслийн явц, түүний ач холбогдол нөлөөллийн талаарх нийт 112 мэдээ мэдээлэл, 46 рийл, 5 ярилцлага хийж бэлтгэсэн. Төслийн мэдээлэл органик байдлаар олон нийтэд хүрч байна. Тухайлбал, Нэгдсэн төслийн удирдлагын газар фэйсбүүк пэйж 12,550 лайктай болж, "Нэгдүгээр тойрог замын гүйцэтгэгчийг шалгарууллаа" гэсэн рийл 15 мянган үзэлт хүрч, бусад рийлүүдийн үзэлт 3-6 мянгын хооронд байна.</p> <p>Мөн санал, хүсэлт хүлээн авах, мэдээлэл солилцох цахим сувгийг нэвтрүүлснээр хэрэглэгч төвтэй үйлчилгээний чанар, хүртээмжийг</p> <p>100</p>

147	333	Онцгой нөхцөл байдлын асуудлаар авах арга хэмжээний тухай 2026-03-04 Дугаар 2026_03	2.3.. 2.3. Өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй болон ёс зүйн зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцож ажиллах.	нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн. Иргэд байгууллагын талаар санал хүсэлт ирүүлснийг холбогдох албан хаагчид уламжилж байна. Цаашид төслүүдийн мэдээллийг иргэдэд илүү ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэх зорилгоор мэдээллийн сан, дижитал платформуудыг боловсронгуй болгох, цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр үе шаттай арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. https://www.ipiu.mn/home	100
-----	-----	---	--	--	-----

ХЯНАСАН:





ЗАХИРАЛ

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
АЛБАНЫ ДАРГА

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

БОЛОВСРУУЛСАН:

БОДЛОГО, ШИЙРВЭРИЙН
БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН


 Э.ТҮВШИНЖАРГАЛ
 Ж.ЛХАГВАСҮРЭН
 Ц.ТУЯА

Б.ЭНХСҮЛД

